

ДЭМБ, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар ба НҮБ-ын ХДХВ/ДОХ-той тэмцэх хөтөлбөрийн опиоидын хараат байдлын орлуулах эмчилгээ болон ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх талаарх хамтарсан баримт бичиг

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар ба НҮБ-ын ХДХВ/ДОХ-той тэмцэх хөтөлбөрөөс опиоидын хараат байдлын орлуулах эмчилгээний талаар байр сууриа илэрхийлсэн хамтарсан баримт бичиг гаргаад байна. Шинжлэх ухааны үндэслэлтэй баримт нотолгоонд тулгуурлан бодлого боловсруулагчдад чиглэсэн энэхүү баримт бичиг орлуулах эмчилгээний зорилго, мөн чанараас аваад ХДХВ/ДОХ-той хүмүүст уг эмчилгээг хүргэхэд анхаарах онцлог зэрэг өргөн хүрээний асуудлыг хамруулжээ.

ДЭМБ, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар болон НҮБ-ын ХДХВ/ДОХ-той тэмцэх хөтөлбөрийн орлуулах эмчилгээний талаарх хамтарсан мэдэгдэл¹

Опиоидын хараат байдал нь ихэвчлэн удаан хугацааны тусламж, эмчилгээ шаарддаг эрүүл мэндийн ярвигтай асуудлын нэг мөн бөгөөд опиоидыг бохирдсон зүү тариур хэрэглэсэн тохиолдолд ХДХВ-ийн халдварт өртөх өндөр эрсдэлтэй. Мансууруулах бодисын шалтгаант хараат байдлыг эмчлэх нь ийм байдалд орсон хүмүүсийн сайн сайхан болон нийгмийн идэвхтэй байдлыг дээшлүүлэх, уг байдлаас үүдэн хүмүүсийн эрүүл мэнд болон нийгэмд үзүүлж буй сөрөг нөлөө, түүний дотор ХДХВ-ийн халдварыг бууруулах чухал стратеги юм. Опиоидын шалтгаант хараат байдалд орсон бүх хүнд үр өгөөжтэй дан ганц эмчилгээний арга байдаггүй тул янз бүрийн, хангалттай олон арга байх шаардлагатай. Опиоидын шалтгаант хараат байдлыг эмчлэх хамгийн үр дүнтэй нэг арга бол орлуулах эмчилгээ юм. Энэ эмчилгээ нь гэмт хэрэг, ХДХВ-ийн халдварт өртөх өндөр эрсдэлтэй зан үйл, хараат байдлаас үүдсэн үхэл эндэгдэл, героины хэрэглээ зэргийг багасгах замаар опиоидын шалтгаант хараат байдлын улмаас хувь хүн, түүний гэр бүл болон нийт нийгэмд учрах үлэмж гарз хохирлыг бууруулах боломжтой. Мансууруулах бодис судсаар хэрэглэгчдийн дунд зохион байгуулах ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх болон опиоидын шалтгаант хараат байдалтай тэмцэх хамт олонд түшиглэсэн олон ажлын онц чухал бүрэлдэхүүн хэсэг нь орлуулах эмчилгээ билээ. Опиоидын шалтгаант хараат байдлынх нь түвшин өндөр, ялангуяа ХДХВ болон цусаар дамждаг бусад вирусийн халдварт өртөх өндөр эрсдэлтэй мансууруулах бодис судсаар хэрэглэгчдэд хүргэж буй, тодорхой судалгаанд үндэслэсэн бөгөөд зохих үнэлгээ, сургалт, магадлан итгэмжлэлээр дэмжигдсэн орлуулах эмчилгээг эмчилгээний чухал арга гэж анхааран үзэх шаардлагатай.

¹ Энэхүү баримт бичигт заасан "орлуулах эмчилгээ" нэр томъёонд дараах эмчилгээг хамруулна. Үүнд: орлуулах эмийн бодис нь сайтар үнэлэгдсэн байна, эмнэлгийн практикт хэрэглэгддэг эмчилгээг магадлан итгэмжлэгдсэн эмч хийнэ, клиникийн зохих хяналттай байх ёстой.



World Health
Organization



UNITED NATIONS
Office on Drugs and Crime



UNAIDS
UNICEF • WFP • UNDP • UNFPA • UNODC
ILO • UNESCO • WHO • WORLD BANK

Дээр дурдсан баримт бичгээс...

“...Опиоидын шалтгаант хараат байдалтай хүмүүст бүгдэд нь тохирох, адилхан үр дүнтэй дан ганц эмчилгээ байдаггүй. Опиоидын шалтгаант хараат байдалтай хүмүүсийн харилцан адилгүй эрэлт хэрэгцээг хангах эмчилгээний олон арга хүртээмжтэй байх шаардлагатай”.

“Орлуулах эмчилгээ нь опиоидын шалтгаант хараат байдалтай тэмцэх үр дүнтэй, аюулгүй, ихээхэн үр ашигтай арга юм. Ахин дахин явуулсан нарийвчилсан үнэлгээ нь опиоидын шалтгаант хараат байдлыг үр дүнтэй зохицуулах болон мансууруулах бодис судсаар хэрэглэгчдийг ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлын үнэ цэнтэй бөгөөд чухал хэсэг болохыг харуулж байна”.

“Цаг алдалгүй эмчилгээнд хамрагдах, эмчилгээний хугацаа урт, тасралтгүй үргэлжлэх, эмийг зохих тунгаар нь хэрэглэх зэрэг нь опиоидын орлуулах эмчилгээний үр дүнг улам сайжруулна гэдгийг баталж байна.”

“Опиоидын хараат байдалтай хүмүүсийн биеийн байдал нь биеийн байдал нь тогтвортой сайжрах, амьдралын сайхныг мэдэрч, нийгэмд гүйцэтгэх үүрэг нь өсөн нэмэгдэх замаар орлуулах эмчилгээний ашиг тусыг хүртдэг. Орлуулах эмчилгээ хийлгэж буй хүмүүс өөрсдийн бие бялдар, сэтгэл санааны амьдрал, бусадтай үүсгэсэн харилцаандаа, тэр ч бүү хэл хамт олон, нийгэмдээ үнэтэй хувь нэмэр оруулах чадвартаа чухал дэвшил хийж чадна”.

“Орлуулах эмчилгээний үр дүнд нийгэмд гэмт хэрэг буурах, эрүүл мэндийн болон гэмт хэрэг шүүх зардал багасах, ХДХВ ба цусаар дамждаг бусад халдвар буурах, хөдөлмөрийн бүтээмж дээшлэх зэрэг эерэг өөрчлөлтүүд гарна. Нэг хүний эмчилгээний улмаас хэмнэгдсэн хэмжээ нь оруулсан зардлаас хавьгүй илүү байгаа нь опиоидын хараат байдлын орлуулах эмчилгээнд хөрөнгө оруулах шаардлагатай гэдгийг харуулж байна.”

“Опиоидын шалтгаант хараат байдлын орлуулах эмчилгээ нь ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх үр дүнтэй стратеги тул энэ ажлыг ХДХВ/ДОХ тархах эрсдэлтэй хүмүүс болох опиоидыг судсаар хэрэглэгчдийн дунд аль болох эрт хэрэгжүүлэх шаардлагатай. Орлуулах эмчилгээг ХДХВ-ээс урьдчилан сэргийлэх болон ХДХВ/ДОХ-той амьдарч буй хүмүүст үзүүлэх бусад эмчилгээ, тусламж үйлчилгээтэй хослуулан хүргэх хэрэгтэй”.

Орлуулах эмчилгээ нь тодорхой судалгаанд үндэслэсэн бөгөөд зохих сургалт, үнэлгээгээр дэмжигдсэн байх шаардлагатай. Клиникийн хамгийн сайн туршлагыг ашиглах, эмчилгээний чанар, үр дүнг хянах, хяналтын зохих арга хэмжээ авах болон эмийг санаатайгаар хууль бусаар ашиглахыг зохицуулах замаар гарч болзошгүй сөрөг үр дагаврыг аль болохоор багасгах хэрэгтэй”.

ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх болон опиоидын шалтгаант хараат байдалтай тэмцэх

орлуулах эмчилгээний талаарх баримт бичиг, 2004, ISBN 92 4 1591153

ДЭМБ хэвлүүлэв. Зохиогчийн эрхээр хамгаалагдсан.

ДЭМБ-ын хэвлэн гаргасан бүтээлүүдийг Маркетинг ба Түгээлт, ДЭМБ, 20 дугаар Аппиа Авеню, 1211 Женев 27, Швейцари улс гэсэн хаягаар олж авч болно.

(утас: +41 22 791 2476; факс: +41 22 791 4857; имэйл: bookorders@who.int).

ДЭМБ-аас хэвлэн гаргасан бүтээлийг олшруулах эсвэл орчуулах зөвшөөрлийг (худалдах эсвэл ашгийн бусаар түгээх зорилгоор) дээрх хаягаар хандан авч болно (факс: +41 22 791 4806; имэйл: permissions@who.int).

Дараах хаягаар уг баримтыг авч болно. Үүнд:

http://www.who.int/substance_abuse/

<http://www.unodc.org/>

<http://www.unaids.org/>

Хэвлэмэл бүтээл авахыг хүсвэл publications@who.int хандана уу.